



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/04

Бодь


Хилийн цэсийн гадна олгогдсон нэгж талбарын зөрчлийг арилгах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан “Харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын заавар”-ын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хилийн цэсийн тодруулалтын ажлыг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна буюу өөр сумын нутаг дэвсгэрт газар эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах, сумын нутаг дэвсгэрт өөр сумаас эзэмших, ашиглах эрх олгосон нэгж талбаруудыг шилжүүлэн авах ажлыг зохион байгуулан ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох хууль журмын дагуу хилийн цэсийн гадна олгогдсон нэгж талбаруудын зөрчлийг арилгаж, дүгнэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 26-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Газрын даамал (Н.Хорлоо)-д даалгасугай.


ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

642201179

Сумын Засаг даргын 2022 оны 09 дугаар  
сарын 05 -ны өдрийн 19 тоот  
захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч

Н.Сумъяа

(Засаг даргын орлогч)

Гишүүд

Б.Баяраа

(Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Н.Хорлоо

(Газрын даамал)

С.Ганцэцэг

(Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Ж.Лхагвасүрэн

(Уубулан 1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Наранбаатар

(Хүйс 2 дугаар багийн Засаг дарга)

У.Батцэцэг

(Хөнөг 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Мөнхбат

(Цагаан ус 4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганцэцэг

(Бодь 5 дугаар багийн Засаг дарга)

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_